# “Миний охины гэр бүлийнхэн 1995 оны аймшигт Ханшин газар хөдлөлтийн үед хамгаа лагдсан билээ!”

**Садао Такахаши ахлагч** (Ида Манмин Сүм, Япон Улс)



Ахлагч Сафао Такахаши болон түүний эхнэр Мицуко Такахаши сүмд үйлчлэгч гэрийнхээ урьд талд

Миний эцэг эх Христийн итгэгч нар байсан ба би номлогчийн сургуульд бага байхдаа сурдаг байв. Гэвч дээд сургуульд орсоныхоо дараа би муу найз нөхдүүдтэй нилээд архи тамхи ууж эхлэв. Эцэст нь би сүмд очихоо болив. Сургуулиа төгссөний дараа би ажилд орон дахин сүмд очиж эхлэсэн боловч миний амьдрал бас л адил байдгаараа л байв.

1994 оны Тавдугаар сард манай гэрийн ойролцоо нэгэн өндөр өнгөт гэгээтэй загалмайтай сүмд эхнэрийнхээ хамт Ням гаригын өглөө очиж оролцов. Миний итгэл тухайн үед маш эмзэгхэн байсан ба би тэр сүмд тэрхүү гайхамшигт загалмайн гэрэлд шохоорогдон хүрч очив.

Миний тэрхүү очсон сүм маань Ида Манмин Сүм байсан ба Пастор Руй Сеунг-гил 3 сарын өмнө үүсгэн бий болгосон байв. Таван сарын дараа Аравдугаар сард би Библиэс уншиж байгаад Дуулал 94:17-18, “Хэрэв ЭЗЭН надад тус болоогүйсэн бол Миний сэтгэл удахгүй чимээгүйн дунд оршихсон. Хэрэв би “Миний хөл хальтирсан” гэж хэлэх ёстой байсан бол, Өө, ЭЗЭН, Таны хайр энэрэл намайг түших байсан.” хэмээн хэлсэн байхыг олж уншиж мэдэв. Сүмд явж эхэлснээс хойш миний сэтгэл зүрх шинэчлэгдэн миний амьдрал өөрчлөгдсөн билээ.

1995 оны Нэгдүгээр сард хүчитХаншин газар хөдлөлт явагдах үед Бурханы агуу гайхамшгыг олж харсан билээ. Газар хөдлөлт болохоос өмнө би өөрийнхөө эхнэр болон миний хоёр хүү маань гэрээсээ гарч амжсан боловч охин маань гарч ирж чадахгүй байгаа байдалтай хоёр удаа зүүдлэв. Зүүдэндээ би охиноо хэн нэгнийг дуудан уйлж байхыг сонсов. Эхнэр бид хоёр түүний төлөө болон охиныхоо гэр бүлийнхэний төлөө Даниелын Залбирлын цаг дээр залбирцгаасан юм.

Дараагын өдөр нь газар хөдлөлт болсон ба миний охины амьдардаг газар нь хамгийн их нэрвэгдсэн байсан тул бид охинтойгоо холбогдохгүй 3 өдөр болцгоов.

Газар хөдлөлтийн үеэр галт тэрэг өнхрөн ойчсон тул маш олон барилгууд нурж унасан байлаа. Гэвч миний охины амьдардаг байранд ямар ч гэмтэл хохирол учраагүй бүрэн хамгаалагдсан байсан ба тэр орчмын хүмүүс Христэд итгэцгээе хэмээн ярьцгааж байлаа. Бурханы агуу хайр энэрэл ивээлд миний зүрх сэтгэл маш их догдлон баярласан юм.

1995 оны Дөрөвдүгээр сард би Манмин Залбирлын Төвийн ахлагчХатагтай Лее Бокним гуайн Ида Манмин Сүмийн ойн баярт үйл ажиллагаа ба онцгой залбирлын цуглаанд оролцов. Тэрбээр миний төлөө залбирал хийжөгөхөд миний биеэр хамаг хөлс асгаран халуу дүүгэн хамраас минь маш их шингэн ус урсан гоожив. Үүний дараа би архи уухаа зогсон аравны нэгийнхээ өргөлийг байнга өргөн Ням гаригийн үдээс хойшхи мөргөлд хүртэл байнга оролцдог болов. Тун удалгүй, би Даниелын залбирлынцаг болон Үүрийн залбирлын цуглаанд оролцдог болов.Тун удалгүй, би Даниелын залбирлын цаг болон Үүрийн залбирлын цуглаанд оролцдог болов.

Би 1935 онд төрсөн ба одоо би 75 настай боловч Бурханы авралаар миний бие сайн хэвээрээ тул гадаад орнуудад аялах боломжтой байдаг билээ. 2009 онд би Иерусалим хотноо болсон 2009 оны Олон Улсын Үндэсний Фестивалд оролцон Доктор Лее Жаерокийн үйл ажиллагаанд очсон ба энэ жил би 2010 оны Манмин Зуны цуглаанд эхнэрийнхээ хамт оролцов. Муаны ус хэмээх далайн давст ус Бурханы агуу гайхамшгаар цэнгэг ариун ус болгогдсон яг л Египетээс гарсан нь 15:25-д дурдсан шиг сайхан газар очиж амрав. Тэнд би 4 жилийн турш хөлийн эвэршилт өвчнөөсөө Муан усанд хөлөө дүрсэнээр эдгэрсэн билээ.

“АмийнҮр”хэмээх 4 цувралын хэсэгтэй сургаалыг Доктор Лее Жаерок гуай биднийг 10 удаа сонссоорой хэмээн уламжлан хэлэв. Би тийнхүү даган хийв. Тэр сургаалыг 10 удаа сонсох үед миний саарал буурал үс маань бага багаар харлан төлжиж байгааг олж мэдэв. Толгойн оройн хэсэг үс маань харлан залуужив. Баруун өвдөгний өвдөлт маань алга болсон байсан ба тэр ч бүү хэл санхүүгийн хувьд ч ерөөлийг хүртлээ.

Исаиагын 46:3-4-д, “Иаковын гэр ба Израилийн гэрээс үлдэгсэд бүгд сонсогтун. Та нар Надаар эхийн хэвлийд тээлгэн, Надаар төрсөн. Тэр ч байтугай та нарыг өндөр настай болсон ч Би хэвээрээ байна. Та нарын үс буурал болсон ч Би тээх болно. Би хийсэн, Би авч явна.

Би тээж, аварна.” хэмээн хэлсэн байдаг. Бурханы сургаал номлолыг даган мөрдөх нь надад ямар гайхамшигт сайхан санагддаг юм.



# “Бид гэрлээд 5 жилийн дараа л хүсэн хүлээсэн хүүхэдтэй болов”

**Алекс Лукас ба Фиона Лукас**
(Сингапур улсын Дахин Сэргээлтийн Сүм)

Их Эзэндээ хандан бид энэхүү талархалаа өргөн барьж байна. Мөн түүчлэн, Доктор Лее болон түүний бидний төлөө залбиралд туйлын ихээр талархаж байна.

Бид 2003 онд гэрлэсэн бөгөөд үр хүүхэдтэй болж чадахгүй л байлаа. Гурван жилийн дараа 2006 онд бид өөрсдийнхөө гэр бүлд үр хүүхэдтэй болохын тулд гол зорилгоо болгов. Бид хоёр жилийн турш хүүхэдтэй болохын тулд бүх сайн гэсэн аргыг хэрэглэсэн боловч ямар ч амжилтанд хүрсэнгүй. Бид орчин үеийн анагаах ухааны эм бэлдмэл болон Хятадын үндэсний уламжлалт эмийг ч хүртэл хэрэглэсэн боловч ямар ч үр дүнд хүрсэнгүй.

2008 оны Есдүгээр сард бид Бурханы авралаар Манмин Төв Сүм дээр ирж Сүмийн Пастор Доктор. Лее Жаерок тэй уулзсан юм. Тэрбээр миний толгойн дээр гараа тавин надад болон миний эхнэрийн төлөө залбирал хийж өгөв. Үүний дараа миний эхнэр 2009 оны Арванхоёрдугаар сард жирэмсэн болсон ба бид анхныхаа хүүхэд Лукасыг хүлээн авав. Агуу Бурхан бидний хүссэн бүх зүйлсийг хайрлан өгч бүх зүйлс сайхан болсон билээ. Лукас эрүүл чийрэг, ухаалаг сэргэлэн цовоо хүүхэд билээ.

2008 онд бид Манмин сүмд анх удаагаа очсон ба Доктор Лее бидний төлөө залбирал хийж өгсөн бөгөөд, 2009 онд бид дахин Манмин сүм дээр Лукасыг төрөхөөс өмнө очсон ба 2010 онд манай гэр бүлээрээ зуны цуглаанд оролцсон юм. Тэнд бид Бурханы агуу гайхамшгуудыг олж харан соннууд ирэн бидний болон Лукасын толгой дээр бууцгааж байв. Цаг агаар ч үнэхээр сайхан байсан билээ.

Манмин сүм дээр ирэх болгонд сүмийн гишүүд биднийг найрсагаар угтан хүлээн авдаг байсан ба энэ нь бидэнд маш сайхан таатай уур амьсгалыг бүрдүүлдэг байв. Доктор Лее Жаерок тэй биечлэн уулзаж залбирлыг хүлээн авах боломжтой байдагтаа би маш их баяртай байдаг билээ. Сингапур улс руугаа буцсаны дараа бид дахин хүүхэдтэй болохоо мэдсэн ба хүүхэд маань 2011 оны Дөрөвдүгээр сард төрөх билээ.

Эдгээр бүх гайхамшигт ивээлийг бидэнд хайрласан Тэнгэрлэг Эцэгтээ хандуулах өргөх хүсэлтэй байна. Бурхан Доктор Лее Жаерокийг болон Манмин Төв Сүм ба түүний дэлхий даяарх салбар сүмүүд болон гишүүдийг ивээж ерөөхийг хүсэн гуйж байна!

Хүндэтгэсэн,
Алекс, Фиона ба Лукас…
Сингапур
2010 оны 10-р сарын 03

## Мөргөлийн цаг

| Мөргөл | Цаг |
|---|---|
| Их мөргөл | Ням гариг 10: 30 |
| Үдээс хойшх мөргөл | Ням гариг 13: 40 |
| 3-дахь өдрийн мөргөл | 3 дахь өдөр 18: 00 |
| 5-дахь өдрийн мөргөл | 5 дахь өдөр 22: 00 |
| Хүүхдийн мөргөл | ням гариг 10: 30 |
| Сурагч залуучуудын мөргөл | Хагас сайн өдөр 16: 30 |

## Залбирлын цаг

| Ангилал | Цаг | Удирдагч |
|---|---|---|
| Даниел үүрийн залбирал | Даваа- баасан 05: 00- 06: 00 | Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч) |
| Даниел өдрийн залбирал | Даваа- баасан 09: 00- 10: 00 | П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч) |
| Даниел оройн залбирал | Өдөр бүр 18: 30- 20: 00 | П. Батзориг (Чуулганы хариуцагч) |



**Хаяг:** Баянзүрх дүүрэг,
13-р хороолол 6-р хороо,
ой булан- 6 иргэний А.О.С
**Утас:** чуулганы- 5525-7637
чуулганы хариуцагч- П.
Батзориг 9117-0773

www.manmin.or.kr
www.manmintv.org

Манмин Мэдээ
NO. 8 2010 оны 12 дугаар сар 5

# “Хятад, АНУ болон Европийн Холбооны орнуудын хүчний хооронд Хойд Солонгос улсад юу тохиолдох бол?”

## Доктор Лее Жае рокийн Ням гаригийн Өглөөний Их мөргөл

“Би дэлхийн нөхцөл байдлыг сайтар ойлгож байдаг тул бид итгэлийнхээ үүднээс маш сэрүүн байх хэрэгтэй.” Аравдугаар сарын 24-нд Манмин Төв Сүмийн Тэргүүн Пастор Доктор Лее Жаерок гуай Амосын 3:7-д дурдсан сургаалын дагуу “Дэлхий Ертөнцийн Өнгө Аяс” хэмээх сэдэвт сургаалиар сүмийнхээ итгэгчдэд зориулан дэлхий ертөнцийн ирээдүйн өнгө аясын талаар зөгнөл болон ялангуяа Хятад, АНУ болон Европын Холбооны улс хоорондын өрсөлдөөнт асуудлын талаар сургаал айлдлаа.

Олон жилийн өмнөөс Хятад улс АНУ-тай өрсөлдөхөөр бэлдэж байсан билээ. Хятад улс нь өөрийнхөө мөнгөн хүүний хувийг өсгөж байсан нь АНУ-ын дарамт шахалтаар биш харин Хятад улс өөрийн эрх ашгийн төлөө тийнхүү өсгөсөн байв. Энэ нь өнөө үед АНУ болон Хятад улс энэ зэрэгцэн өрсөлдөх тавцанд хүргэсэн билээ. Чеонан хэмээх хөлөг онгоцыг живүүлсэн тохиолдолд Хятад улс ямар ч мэдэгдэл санаа бодлоо илэрхийлээгүй билээ.

Мөн түүнчлэн Хятад улс Япон улстай аралын мөргөлдөөнөөс болж дипломат харилцааны сөргөлдөөнд орсон ба энэ нь тус улсын нөхөрсөг энгийн хамтын үйл ажиллагааны сөрөг талыг харуулав. Америкийн Нэгдсэн Улс болон Европын Холбооны орнуудын юанийн үнийн шахалтанд онцгой анхаарсан байдлыг Хятад улс үл тоомсорлосоор байгаа билээ. АНУ-тай одоогын байдлаар сөргөлдөөнтэй байдалтай байгаа учир шалтгаан нь эдийн засгийнх боловч үүнээс үүдэн улс төр, дипломат харилцаа болон зэвсэгт хүчний асуудлууд гарч байгаа билээ. Энэхүү тулгамдсан асуудалд АНУ маш ихээр алдагдалд орох боловч хамгийн ихээр АНУ-ын эдийн засагт тулгуурладаг маш олон орнууд хүндээр хэлмэгдэн хэцүү нөхцөл байдалд орцгоох билээ. АНУ болон Хятад улс хоёрын хоорондын тэмцэлдээнийг харж байгаа Европын Холбооны орнууд тийнхүү хүнд нөхцөл байдалд орохгүйн тулд одооноос эхлэн гэнэтийн тулгамдсан асуудалд орохоос болгоомжлох болно. Европын Холбооны улс Хятад улстай санал нэгдэх аваас хүнд байдалд орох учраас Хятад АНУ-ын хоорондын мөргөлдөөнд ямар ч дуу хоолойгоо оруулахгүй нам гүм байдалтай байх болно. Тиймийн тул, Европын Холбооны улс өөр хоорондоо маш ойртон нэгдэцгээн ирээдүйдээ бэлдэцгээх болно. Цаг нь болохоор Хятад улс Европын Холбооны улсыг өөртөө татахыг оролдовч тэдний бодол санаа нь буруу байсныг нэн даруй олж мэдэн Европын Холбооны улсуудтай мөргөлдөөн орно. Үүнээс болж дэлхийн маш олон орнууд тэрхүү гурван гүрний хоорондын мөргөлдөөнөөс болж Европын Холбооны улс руу олон орнууд чиг хандлага чиглүүлцгээх болно. АНУ өөрийнхөө хүч чадлыг олон улсын хүрээнд бий болгохын тулд өөр чиг хандлага бий болгох гэж оролдох болно. Тэрхүү өөр чиг хандлага нь Ойрхи Дорнод юм. Үүнээс үүдэн АНУ нь Ойрхи Дорнодтой мөргөлдөөн орох болно.

Энэхүү зөгнөл сургаалын эхэнд, Доктор Лее гуай, “Энэ жилд манай сүмийн залбирлын сэдэв 1рт “Сүнсний Урсгал” 2рт “Итгэлийн Хэмжээ” гэсэн сэдвүүдийг Бурханаас айлдсан зүйл бөгөөд магадгүй та бүхэн энэ жил сүнсний урсгалыг харж Бурхан бидэнд энэ жил яагаад “Итгэлийн хэмжээ” гэсэн залбирлын сэдвийг өгсөнийг ухаарч байгаа байх. Хэрэв таны итгэлийн одоогын байдал ямар нэгэн талаар зогсонги унтаа байгаа бол энэ сүнсний урсгалыг ухаарах хэрэгтэй билээ. Та бүхний хэн нэгэн нь тийнхүү итгэлийн зогсонги байдалд орсон байгаа бол энэ сургаалиар дамжуулан сүнсний урсгалыг ойлгож мэдрээсэй хэмээн хүсэж байна.” хэмээн дурдан хэлсэн билээ.

Доктор Лее Жей Рок пастор нь маш олон зүйлсийг зөгнөн хэлсэн байсан ба тэдгээр зүйлсүүд биелэлүүдээ олцгоосон билээ. 2000 онд Өмнөд Солонгос улсын ерөнхийлөгч Ноён Ким Даежунг Хойд Солонгос ард улсын удирдагч Ким Жонг-Ил ийн урилгаар Хойд Солонгост айлчилсан билээ. Агуу удирдагч Өмнөд Солонгос улсад хариу барин айлчилах болно хэмээн мэдэгдсэн билээ. Солонгос улсын хэвлэл мэдээлэлийн албаны сурвалжлагч нараас гадна дэлхийн маш олон улсын хүмүүс хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр дамжуулан тэрхүү айлчилыг үзэж харцгаасан билээ. Хэдий тийм боловч Доктор Лее гуай Хойд Солонгосын Үндэсний Батлан Хамгаалахын Тэргүүн Ким Жонг-Ил ыг Өмнөд Солонгос улсад айлчилахгүйг зоригтойгоор



*Өдөр Тутмын Жонг-Анг Сэтгүүл, МБС (Маел Бизнес Сүлжээ), Ёнхап Мэдээнүүд,* СБС (Сөүл Хэвлэл Мэдээлэлийн Систем)

тунхаглан хэлсэн билээ. Тэрхүү айлчиллаас хойш Хойд Солонгос улсын удирдагч Ким Жонг-ил өнөөдрийг хүртэл айлчилаагүй байгаа билээ. 1987 онд Доктор Лее гуай 6. 29 хэмээх Өмнөд Солонгос ард улсын үндсэн хуулийн нэмэлт заалтын тунхаг бичгийн талаар дурдан хэлсэн ба 13, 14 болон 15-р ерөнхийлөгчөөр Роу Тае-воо, Ким Юнг сам болон Ким Даежунг нарыг сонгогдох талаар урьдаас зөгнөн хэлсэн билээ.

Энэхүү зөгнөлийг гаргаад 5 жил 8-н сарын дараа буюу 2005 оны 2-сарын 20-нд Доктор Лее гуайн зөгнөлийг нийтлэн гаргасан билээ. Тэрбээр долоо хоног болгон Бурхантай гүн холбогдон харилцдаг бөгөөд Бурхан түүнд бараг долоо хоног болгон дэлхий дахины үйл байдлын талаар айлдаж мэдэгдэж байдаг билээ. Бурхан түүнд ямар нэгэн ирээдүйд болох зүйлийн талаар нарийн тодорхой хэлж мэдэгдэхээс гадна Их Эзэнийг дахин иртэл хугацаанд болох зүйлсийг ерөнхийд нь айлдсан билээ. Түүний хамгийн сүүлийн зөгнөл болгон хэлсэн зүйлс нь, “Хойд Солонгос улсын дэлхий дахины хавчлага даралтаас болж хийх алхамууд нь Өмнөд Солонгос улсад хэрхэн нөлөөлөх талаар дурдан хэлсэн байдаг. Саяхан Хойд Солонгос улс төрийн эрхийн хүч чадлын өөрчлөлтүүд явагдсаар байгаа ба үүнээс үүдэн маш хэцүү зүйлсүүд тулгарах болно. Удалгүй удирдагч нь олны анхаарлыг татахаа болихоор тэрбээр том чухал шийд гаргах хэрэгтэй болно. Гадаад харилцаагаа бий болгон үүд хаалгаа нээх боловч улс төрийн систем засаг захиргаагаа хадгалан үлдээх нь маш том асуудал болох болно. Хятад болон АНУ-ын нөлөө шахалтаас болж ийм шийд алхам тус улс хийх болно.”





АНУ болон Хятад улсын хоорондох мөнгөний ханшнаас үүсэлтэй дайн





Хятадын мөнгөний хүүгийн өсөлт нь ямар учиртай вэ?





Хятад улс нь Япон улсыг гүйцэн дэлхийд эдийн засгийн хоёр дахь том гүрэн болов





Хойд Солонгосын удирдагчийн хүү нь дараагийн удирдагч болох нь

## Зурагт Мэдээнүүд













Их Эзэний, “Үзэцгээ ба Залбирцгаа” хэмээн хэлсэний дагуу Манмин Залбиралын Төвийн ахлагч Хатагтай Лее Бокним гуай Аравдугаар сарын 11-нээс Арван нэгдүгээр сарын 21-ны хооронд Хоёр удаагын Онцгой Даниелын Залбиралын Цаг хэмээх үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү залбиралын цагт Солонгосын олон мянган итгэгчидоролцож байгаа ба дэлхий даяарЖСН ба интернэтээр шууд нэвтрүүлсэн бөгөөд Залбирлын сэдэв нь “Ерөөл” ба “Эстонийн нэгдсэн цуглааны төлөө”болон “ Сүнслэг хүч” гэсэн сэдэвтэй залбирцгаасан билээ.

“Загалмайн Сайн Мэдээ” Цувралууд -(7)

# Есүс Яагаад Бидний Аврагч юм бэ?

## -Хүн Төрөлхтөний авралын зам нь Газар Золих Хуулиар шийдэгддэг-

“Бид төлөвшсөн хүмүүсийн дунд мэргэн ухааныг ярьдаг. Ингэхдээ энэ үеийн мэргэн ухааныг бус, өнгөрөн одож буй энэ үеийн удирдагчдын мэргэн ухааныг ч бус, харин нууц дотор буй Бурханы мэргэн ухааныг бид ярьдаг. Энэ нь бидний алдрын төлөө үеүдээс ч өмнө Бурханы урьдаас тогтоосон нуугдмал мэргэн ухаан мөн.” (1 Коринт 2:6-7).



Доктор И Жэй руг

Христэд итгэгч хүнүл итгэгч болон шашингүй хүмүүст бидАврагч Есүс Христийн тусламжтайгаар авралыг хүлээн авах болно гэдгийг хэлэхэд ихэнхи хүмүүс хүлээж авдаггүй бөгөөд тэдний дундаас зарим хэсэг нь Христэд итгэдэг хүмүүсийг “өөрсдийгөө зөвт хэмээн боддог хүмүүс” хэмээн нэрлэцгээдэг. Тийм ч учраас бид яагаад Есүс Христ нь бидний аврагч болсон талаар бүх хүмүүст ойлгуулахын тулд тайлбарлаж өгөх хэрэгтэй.

*1. Адам үхлийн харгүй руу хаягдсаннь*

Гай зовлон гэж мэдэхгүй буюу даван туулаагүй байж аз жаргалыг ойлгож мэдрэх боломжгүй билээ. Гай зовлонд нэрвэгдэн туулж өнгөрөөснийхөө хариуд л хүмүүс аз жаргалыг ойлгон чин сэтгэлээсээ баяр баясгалан талархалыг өргөн барьдаг байдаг билээ.

Хүн төрөлхтөн үүнийг ухааран ойлгож мэдэхийг хүсэж байсан тул Бурхан сайн мууг мэдүүлэгч модыг бий болгон Адамыг түүнээс идэхийг хориглон хэрэв идэх аваас үхэх болохыг сануулан хэлдэг. Мөн түүнчлэн, Бурхан Адамд чөлөөт сонголтыг бий болгон өөрийнхөө оюун ухаанаар шийдвэр гаргах боломж олгосон ба Адам тэрхүү сайн мууг мэдүүлэгч хориотой жимснээс идэн Бурханы сургаал тушаалыг зөрчдөг.

Зарим хүмүүс, “Адамд ямар ч нүгэл байхгүй байхад тэрбээр хэрхэн нүгэл хийсэн юм бэ?” хэмээн асууцгаадаг. Адамын зүрхний угт нүгэлт зан байдал байсан болохоор тэрбээр сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идсэн байх гэх ярианы талаар эрхэм та ухааран ойлгох хэрэгтэй. Сайн мууг мэдүүлэгч модны жимснээс өөрийн чөлөөт сонголтоороо идсэнээс болж түүний зүрх сэтгэлд нүгэл хуралдан бий болж сайн мууг танин мэдэх болов. Нүгэл хилэнцээр дүүрэн байгаа өнөө үеийн хүмүүсийг хараад Адамын зүрх сэтгэлд ямаршуухан гэм нүгэл хуралдан бий болж байгааг ойлгож болох юм.

Жишээлбэл, 1 хүүхэд бусад хүүхдүүдийг цохих зуршил нь анхнаасаа биш юм. Мэдээж тэр хүүхэд анх төрөхдөө угын нүглийн шинж чанартай төрсөн тул тэр нь нөлөөлсөн байх нь зайлшгүй юм. Гэхдээ тэр хүүхэд хүн цохих дадал зуршилыг байнга бий болгосоноор нүгэлт зам руу хөтлөгдөн ордог ба үүнд ямар үе шат дамжсан нь маш их нөлөөлдөг. Эхлээд хүүхэд өөр нэгэн хүнийг цохиж байгааг олж хараад бусдыг ганц хоёр цохиж авах болон үүнээсээ цаашлаад бусад хүмүүсийг цохиж гэмтээх нь энгийн үзэгдэл болон хувирдаг билээ.

Могойн ятгалганд орон Адам чөлөөт сонголтоороо сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идсэн юм. Бурханы айлдахдаа, “Чи зайлшгүй үхэх болно” хэмээн айлдсан бөгөөд хүнийг удирдагч болох сүнс нь үхдэг. Адам Бурхантай холбоотой байсан тэрхүү байдал нь тасарч Сатан болон атгаг сүнснүүдийн боол болдог билээ.

Ром 6:16-д, “Та нар өөрсдийгөө дуулгавартай байхаар боол болгон хэн нэгэнд өгөхдөө, үхэлд хүргэх нүглийн ч бай, эсвэл зөвт байдалд хүргэх дуулгавартай байдлын ч бай, дагах нэгнийхээ боол нь болдгоо мэдэхгүй гэж үү?” хэмээн айлдсанчлан ба гай зовлонгын эх үүсвэр болох чөтгөр ба харанхуйн сүнснүүдийн хараат байдалд боол болон ордог.

Тухайн үед Адам нь газар дэлхий бүх ертөнцийг удирдан захирах эрх мэдэл сүр жавхлан байсан ба үүнийгээ муу ёрын сүнсэнд алдсан(Эхлэл 1:28)бөгөөд Есүсд энэ нь Лукын 4:6-д, “Энэ бүх эзэмшил болон тэдгээрийн сүр хүчийг би Чамд өгье. Учир нь энэ бүгд надад өгөгдсөн юм. Би үүнийг хүссэн хүндээ өгч чадна” хэмээн хэлсэн байдаг.

Адамаас тийнхүү газар дэлхийг удирдан захирах эрх мэдлийг хүлээн авсаны дараа муу ёрын сүнс газар дэлхийд маш их гэм нүгэл хилэнцийг үйлдэхэд хүний зүрх сэтгэлийг гэм нүглээр дүүргэсэн билээ. Муу ёрын сүнснүүд ган гачиг, өвчин зовлон, ядуурал гамшиг, уй гашуу, зовлон тарчлаан зэрэг мөнхийн үхэл болох тамын гай зовлонг энэ дэлхийд авчирдаг билээ.

Хэдий тийм ч гэсэн Бурханы агуу гайхамшигт хайрын төлөвлөгөөний дагуу тамд унаж мөнхөд үхэл рүүгээ явах биш харин зааж сурган хүмүүжүүлснийхээ эцэст Тэнгэрийн оронд үүрдийн мөнхөд амьдрах боломжтой болсон билээ.

Бурхан Адамыг анхнаасаа тийнхүү сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идэх болно гэдгийг мэдэж байсан тул гэм нүгэлт хүн төрөлхтөнийг аврахын тулд авралын төлөвлөгөөг бий болгосон ба энэхүү төлөвлөгөө нь Есүс Христ билээ.

*2. Хүн Төрөлхтөний авралын зам нь Газар Золих Хуулиар шийдэгддэг.*

Тэгвэл бид хэрхэн нүгэлт байдлаасаа ангижран авралыг хүлээн авах билээ? Бурхан бүгдийг үргэлж Өөрийн хайр ивээлээрээ хамгаалаад байхгүй ба энэ маань шударга бус юм. Бурхан үнэнч шударга хүн тул сүнслэг ертөнцийн хууль дүрмийн дагуу шударга үнэн шийдвэр гарган мөнхийн авралыг зохистой хүмүүст олгох билээ.

Тиймээс, нүгэлт ертөнцийн гэм нүгэлт хүмүүсийн гэм нүглийн төлөөсийг төлөхийн тулд Есүс бидний төлөө бидний гэм нүглийг өөртөө аван загалмайн дээр цовдлуулсан билээ. Сүнслэг ертөнцийн хуулинд “Гэм нүглийн төлөөс нь үхэл” хэмээн хэлсэн байдаг. Есүс бидний хийсэн гэм нүглүүдийн төлөөс болгон өөрийнхөө амийг золиослон загалмайн дээр цовдлуулсан билээ.

Есүс Христэд итгэн өөрийнхөө Аврагчаар хүлээн авсан тохиолдолд тус хүн мөнхийн амьдралд орох боломжтой болно. Тэгсэн хүн Есүс Христийн бидний төлөө ариун нандин цусаа асгаруулсныг хүлээн зөвшөөрвөл Бурханы хүүхэд болон ерөөл хайрыг хүртсэнээрээ аз жаргалаар дүүрэн сайхан амьдрах билээ.

Үүнд итгэдэггүй хүмүүс нь биднээс, “Яагаад Есүс Христэд итгэхэд л бид авралыг хүлээн авна гэж ?” хэмээн асууцгааж байдаг. Энэ талаар Библийн Үйлсийн 4:12-д, “Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдсөнгүй гэв.” хэмээн дурдан бичсэн байдаг ба Есүсийг аврагчаа хэмээн хүлээн зөвшөөрөөгүй хүмүүс мөнхийн авралыг хүлээн авах боломжгүй билээ.

Яагаад Есүс л бидний Аврагч гэж? Энэ нь сүнслэг ертөнцийн хуулиар юм. Хүн төрөлхтөн Адамын хийсэн гэм нүглийн дагуу мөнхөд үхэлд “Нүглийн төлөөс нь үхэл юм” хэмээн хэлсэний дагуу болсон байв. Хүн төрөлхтөн Сатан болон түүний дагалдагч болох муу ёрын сүнснүүдийн боол болсон байсан ба “Боол болсон хүмүүс нь эзэндээ үйлчилэн зарцлагдах болно,” хэмээн дурдан бичсэн байдаг.

Сүнслэг ертөнцийн хуулийн дагуу нүгэлт хүмүүс өршөөл уучлалыг хүлээн авч чадна гэж үү? “Нүгэлт ертөнцийн хуулийн” дагуу бид энэ тухай Библиэс уншиж олж мэдэж болно.

Левитын 25:23-25-д, “Газар бол Минийх учир бүрмөсөн зарагдах ёсгүй. Учир нь та нар бол Миний түр суугч, харийнхан болой. Та нарын эзэмших газар бүрийн хувьд, та нар газрын золилтыг олгох ёстой. Хэрэв ах дүү чинь ядуурснаас болж, эзэмшил газрынхаа хэсгийг зарах аваас түүний хамгийн ойрын хамаатан нь ирж, ах дүүгийнхээ зарсныг нь золих учиртай.” хэмээн дурдан бичсэн байдаг.

Энэхүү хууль нь Израйлын газар нутгийг дурдан хэлсэн боловч бүх хүн төрөлхтөний газар нутгийг бэлэгдэн хэлсэн байдаг билээ.

Бурхан Канааны газар нутгийн Израйлын овогт хуваан өгсөн ба тэдгээр газар нутаг нь Бурханаас өгөгдсөн байсан тул тэд зарж үрж болохгүй билээ.

Хэрэв газрын эзэн үгүйрэн хоосорч газар нутгаа зарах болоход түүний ойр дотныхон нь худалдан авч газрын эзэнд буцаан өгөх болдог. Энэ хуультай адил нүгэлт ертөнцийн хууль нь авралын төлөвлөгөөтэй адил юм. Газар нутгийг заран эргүүлэн эзэнд нь өгөх нь хүн төрөлхтөний авралын төлөвлөгөөтэй адил байдалтайгаар сүнслэг ертөнцийн хуулинд заасан байдаг.

Эхлэл 3:19-д, Бурхан Адамд, “Чи газар шороондоо эргэж очих хүртлээ духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ. Учир нь чамайг газар шорооноос авсан. Чи тоос шороо тул тоос шороондоо буцаж очих болно” гэжээ хэмээн хэлсэн байдаг. Эхлэлийн 3:23-д, “ЭЗЭН Бурхан хүнийг өөрийг нь гаргаж авсан газар шороог хагалуулахаар Еден цэцэрлэгээс гарган явуулжээ.” хэмээн дурдан бичсэн байдаг

Газар золих хуулийн дагуу хүн төрөлхтөн нь газар шорооноос бий болгогдсон ба газар дэлхий нь муу ёрын сүнсний мэдэлд орсон байгаад эргээд Бурханд очих юм. Бурханд газар нутаг нь харьяалагддаг шиг Адамын алдсан эрх мэдэл нь ч “зарагдахгүй” байх билээ.

Адамыг нүгэл үйлдсэн тэрхүү үед энэхүү хуульд Бурхан болон Муу Ёрын Сүнс хоёулаа зөвшөөрцгөөсөн билээ. Хэдий Адам муу ёрын сүнсний боол болон бүх эрх мэдлүүдээ тэдэнд алдсан ч гэсэн Газар золиххуулийн дагууүйлдвэл муу ёрын сүнс булааж авсан хүч чадлаа Бурханд “эргүүлэн өгөх” болно.

Бурхан Адамыг анхнаасаа сайн мууг мэдүүлэгч модны жимсийг иднэ гэдгийг мэдэж байсан тул Тэрбээр Аврагчийг газар золих хуулийг гүйцэтгэх хүн болгон Есүс Христийг бэлдсэн билээ. Аврагч болохын тулд ямар шаардлагуудыг даган мөрдөх хэрэгтэй вэ? Би энэ талаар дараагын Манмин Мэдээндээ дурдан хэлэх болно.

Христ доторх ах эгч нар аа,

Гэм нүглийнхээ улмаас мөнхийн сүйрэл рүүгээ хөтлөгдөн явж байсан гэм нүгэлт хүмүүсийн төлөө авралын замыг нээж Газар золих хуулийн дагуу авралын замыг бий болгон аз жаргалтай сайхан амьдралыг хүлээн авах боломж олгосон Бурхандаа алдар ба магтаалыг өргөе хэмээн Их Эзэний нэрээр би залбирч байна!

Mong.
Манмин Мэдээ
Published by Манмин Төв Сүм
235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеүл,
152-848 Солонгос Улс
Утас: 82-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин



<2010 оны Эстони улсад зохиогдсон нэгдсэн цуглааны үйл ажиллагааг шууд нэвтрүүлсэн сувгууд>




# Ариун урсгалын сайн мэдээ ба Бурханы Агуу гайхамшигт хүч чадлаар Европыг сэргээсэн нь

2010 оны аравдугаар сарын 30 болон 31-нд Доктор Лее Жаерок гуай Балтын орнуудын нэг болох Хойд Европын Эстони улсад нэгдсэн цуглааныг зохион явуулав. Тус үйл ажиллагаа нь “Өмнөд Солонгосын Өдрүүд Эстони Улсад 2010 он” хэмээх сэдэвтэй байв. Доктор Лее гуай дэлхийн томоохон орнуудад дэлхий дахинаа нөлөөлсөн энэ мэт нэгдсэн цуглааныг Каталок, Ислами болон Хинду улс орнуудад зохион явуулсан билээ. Тэрбээр 2003 онд Оросын Холбооны Санкт Петрбургэд болон 2004 онд Герман улсын Оберхаусэнд тус тус агуу гайхамшигт нэгдсэн цуглаануудыг зохион явуулав.

### Доктор Лее Жаерокийн Герман улсад хийсэн нэгдсэн цуглаан нь Европын сүмийг идэвхжүүлсэн нь

Доктор Лее Жаерокийн 2004 онд Герман улсад болсон Гайхамшигт эдгэрэлтийн цуглаанд Герман хүмүүсээс гадна Английн Вант улс, Испани, Недерланд, Итали, Франц, Польш болон Белги хэмээх нийт 40 гаруй орнуудаас хүмүүс ирцгээсэн ба тус үйл ажиллагааг 76 орон руу цацан дамжуулав.

3-н өдрийн туршид үргэлжилсэн тэрхүү цуглаанд, Доктор Лее Жаерок сургаал айлдсан бөгөөд “Бүхнийг Бүтээгч Бурхан,” “Есүс Яагаад Бидний Цорын Ганц Аврагч гэж?” болон “Ариун Сүнсний Хүч Чадал” хэмээх сэдвүүдтэй байв. Тус үйл ажиллагааны дараа тэрбээр өвчтэй олон хүмүүсийн төлөө эдгэрэлийн залбиралыг үйлдсэн ба тус залбиралын дараа эдгэрсэн хүмүүс хэрхэн эдгэрсэн талаар гэрчлэцгээж байв. Хараагүй нэгэн нь хараатай болж сонсголгүй нэг нь сонсголтой болцгоов. Түрдэг тэрэгтэй ирцгээсэн хүмүүс нь тэргэнцэрүүдээсээ босоцгоон тайзнаа гарч ирцгээн эдгэрсэндээ талархан гэрчлэцгээж байлаа. Ариун Сүнсний хүч чадлаар хийгдсэн энэхүү гайхамшигт үйл явдлыг хуран цугларсан хүмүүс үзэн шагшин магтацгааж тэд мөн Бурхандаа талархан дуу алдан алга ташицгааж алдрыг өргөж байлаа.

Герман улсад болсон цуглаан нь Герман, Испани, Орос, Франц, Хятад, Япон болон Тамил нийт 8 хэлүүдээр орчуулагдав. Герман хэлний орчуулагч байсан Пастор Клаудиус, Доктор Лее Жаерокийн хуваалцан ярьсан сургаал нь гүн ухагдахуунтай болон сүнслэг үнэнийг агуулсан байсан хэмээн дурдан хэлэв.

Холи Гад ТВ-ын Ерөнхийлөгч болон Амьдралын Усан Оргилуур хэмээх Сүмийн ахлах дастор Герард Утхаякумар тус цуглааныдамжуулалт болон сүмийн үйл ажиллагаанд туслан оролцов. Тэрбээр, “Европын орнуудад Христийн үйл ажиллагаа маш их уруудаж байгаад миний сэтгэл эмзэглэж байдаг байсан ба Христийн нэвтрүүлэг тараан цацах нь маш чухал хэрэгтэй байв.” хэмээв. 2005 оны Хоёрдугаар сард тэрбээр өөрийн санхүүжилтээр “Холи Гад”хэмээх нэртэй суваг Франц улсад цацан гаргав. Холи Гад ТВ-гээс гадна Лав Вөрлд ТВ, Визион Хеавэн ТВ, Алфа Омега ТВ, ТБН-Орос ТВ, СНЛ ТВ болон ЛайфТВ хэмээх маш олон сувгууд болон ЖСН-ээр дамжуулан Европ даяар тараан цацагддаг болов.

Мөн түүнчлэн, Бурханы хүч чадлын тухай болон Доктор Лее Жаерок гуайн маш олон цуврал ном хэвлэлүүд болон Манмин Мэдээнүүд нь Европ даяар тараан худалдагдсаар байна. Доктор Лее гуайн 60 гаруй номнууд нь 47 орны хэлүүдээр орчуулагдсан байгаа ба 123 нийтлэлүүд болон 30-аад номууд 23 орны хэлүүдээр орчуулагдахаар зэхэгдээд байгаа билээ. Түүний томоохон туурвилууд нь Загалмайн Сайн Мэдээ, Итгэлийн Хэмжээ, Тэнгэрийн орон I & II болон Там хэмээх номууд нь юм. Манмин Сүмийн Мэдээнүүд нь долоо хоног, хоёр долоо хоног ба сар тутам 17 хэлнээ орчуулагдаж байдаг ба Бурханы сургаал номлолуудыг тараан түгээдэг билээ.

### Олон улсын Эрүүл мэндийн конференц болон Загалмайн сайн мэдээ хэмээх Европын камп

ДХЭС (Дэлхийн Христийн Эмч нарын Сүлжээ) нь олон улсын байгууллага ба Христийн эмч нарын бүрэлдэхүүнтэй залбиралаар эдгэрэлийг хүлээн авсан хүмүүсийн гэрчлэлийг тогтоон хүлээн авдаг ба Бурханы хүч чадлыг баттгадаг билээ. ДХЭС нь нөлөө бүхий байгууллага ба Европ даяар логик олон учир шалтгааныг хайгч хүмүүст мэдээлэл тараагч байгууллага юм.

2008 оны Гуравдугаар сард 5-р, 6-р 7-р Олон Улсын Христийн Эмч Нарын Конференц уулзалт нь Норвег улсын Трондхэйм хотод, 2009 оны Аравдугаар сард Украйн улсын Киев хотод болон 2010 оны Тавдугаар сард Итали улсын Ром хотноо тус тус зохион байгуулагдав. Европын Христийн Эмч нарын уулзалтанд хамрагдацгаасан маш олон хүмүүс, “Энэхүү гайхамшигт эдгэрлүүд нь шинжлэх ухааны үүднээс ойлгон тайлбарлах ямар ч боломжгүй агуу гайхамшигт үйлс” хэмээн батлан хэлцгээж байсан билээ.

‘Загалмайн Сайн Мэдээ’ хэмээх үйл ажиллагаа нь Европын залуучуудад зориулагдав. Тус арга хэмжээг ММТС (Манмин Миссионар Бэлтгэлийн Төв) 4 удаа зохион байгуулав. Анхны үйл ажиллагааг 2006 онд Франц улсад, 2-р үйл ажиллагааг 2007 онд Швейцар улсад, 3-р үйл ажиллагааг 2009 Белги улсад ба 4-р үйл ажиллагааг Финланд улсад тус тус зохион явуулав. Эдгээр үйл ажиллагааны үеэр маш олон Европын залуучууд Амин үгсийг сонсоцгоон Ариун Сүнсний үйлсийг олж мэдэрэн сүнслэг өөрчлөлтийг хүсэн тэмүүлцгээж байлаа. Ийм эдгэрлийн цуглаанууд Доктор Лее Жаерокийн залбирч өгсөн гар алчуураар нь Европын салбар сүмүүдэд болон Манмин Төв Сүм дээр байнга явагдаж байв.

### Өмнөд Солонгосын 2010 онд Естони улсад хийсэн нэвтрүүлэг нь 220 орнуудад цацагдав

Доктор Жаерок Леегийн Европ тивд зохион явагдаж байгаа Манмин Төв Сүмийн үйл ажиллагаа нь маш амжилттай явагдсанаас улбаалан Эстони улсад бас үйл ажиллагаагаа явуулж эхлэв. Доктор Лее гуайн нэгдсэн цуглааны үйл ажиллагаа зохион явуулахад түүний гайхамшигт сургаалууд нь Их Эзэнийг хүлээн авахад нь маш олон хүмүүст тус нэмэр болцгоож байсан билээ. Аравдугаар сарын 30, 31-д зохион явагдсан нэгдсэн цуглааны үйл ажиллагаа нь ТВ-ын сувгаар 220 орнуудад цацагдан явагдсан ба интернэтээр дамжуулагдав.

Эстони улсад болсон тэрхүү гайхамшигт нэгдсэн цуглааны үйл ажиллагаанд салют мэт Ариун Сүнсний гайхамшигууд бий болон Бурханы гайхамшигт энэрэл ивээл эдгэрлийг маш олон хүмүүс хүлээн авцгаасан билээ. Энэхүү нэгдсэн цуглаанаар дамжуулан сүнсний үхмэл байдалд байсан Европын маш олон Христийн сүмүүдийг идэвхжүүлэн Ариун Сүнсний гал дөлийг бадраав.



Эстони улсын Таллинн хотод хийгдсэн “2010 Өмнөд Солонгос улсын соёлын өдрүүд “үйл ажиллагаа



Итали улсын ДХЭС-ээс удирдан зохион байгуулсан Олон Улсын Христийн Эрүүл Мэндийн 7-р Конференс





Финланд улсын Хелсинки хотод болсон 4-р Загалмайн Сайн Мэдээ үйл ажиллагаа